



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 6᠖ дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/88 дугаар "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлах тухай" захирамж гарсантай холбогдуулан Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын "Шар түвшин"-д 2022 оны 2 сарын 14-ний өдрөөс эхлэн шилжүүлсүгэй.

2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах горим, түүнд тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд нэгдсэн шуурхай штабын дарга (Л.Батсайхан), Онцгой байдлын газрын дарга бөгөөд Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010293



ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

НЭГ. ХУВЬ ХҮН, ГЭР БҮЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

	Хязгаарлах үйл ажиллагаа
Хувь хүн, гэр бүл	<ol style="list-style-type: none"> 1. Халдварын тархалт өндөртэй бүс нутаг руу зорчихгүй байх 2. Ойрын хавьтал болсон эсвэл халдвар батлагдсан хүнтэй уулзахгүй байх 3. Өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, архаг хууч өвчтэй хүн олон нийтийн газраар аль болох явахгүй байх
Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага	
Халдвараас сэргийлэх дэглэм баритлах	<ol style="list-style-type: none"> 1. Олон нийтийн газар, дотоод орчинд амны хаалт зүүх 2. Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих 3. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг сахих 4. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд утсаар зөвөлгөө авах, өөрийгөө тусгаарлах, дэглэм сахих
Дархлаажуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Дархлаажуулалтын тухай хуулийн 6.2.1-д “Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шаардлагын дагуу сэргийлэх тарилга хийлгэх үүрэг хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлэх 2. Дархлаажуулалтад товлот хугацаанд хамрагдах 3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдсаныг нотлох баримт, магадлагааг цахим болон цаасан хэлбэрээр авч явах
Зорчих хөдөлгөөн	<ol style="list-style-type: none"> 1. Аль болох хувийн унаагаар зорчих 2. Хүн хоорондын зай барих 3. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо халдвараас сэргийлэх дэглэм баримтлах

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Хуулийн этгээд	<ol style="list-style-type: none"> 1. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах 2. Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулан ажиллахдаа дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан, эсхүл түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж сөрөг хариу гарсан ажилтан, уран бүтээлч, үйлчлэгч нарыг оролцуулах
Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага	
Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах	<ol style="list-style-type: none"> 1. УОК-оос батлагдсан журмын дагуу байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг мөрдөж ажиллах 2. Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх 3. Улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх 4. Халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх

	5. Ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалах
Дархлаажуулалт	Дархлаажуулалтын тухай хуулийн 7.2-т "Аж ахуй нэгж, байгууллага нь өөрийн ажилтнуудыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлэх
Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллах 2. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах
Зорчих хөдөлгөөн	<ol style="list-style-type: none"> 1. Аль болох хувийн унаагаар зорчих 2. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо халдвараас сэргийлэх дэглэм баримтлах
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	<ol style="list-style-type: none"> 1. Шаардлагатай тохиолдолд асуумж авч нэвтрүүлэх 2. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах